

**Засгийн газрын үйл ажиллагааны  
2004 оны IV сарын товч мэдээлэл  
/2004.04.01.-2004.04.25./**

Монгол улсын Засгийн газар энэ оны дөрөвдүгээр сард үйл ажиллагааныхаа хөтөлбөр, тус улсын эдийн засаг, нийгмийг 2004 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мал хаваржилт, төл бойжуулалт, газар тариалангийн бэлтгэл болон цаг үеийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд гол анхаарлаа төвлөрүүлэн ажиллав.

Засгийн газар Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах хэлэлцээрт оруулахаар санал болгосон нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай хуулийн төсөл, Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын Засгийн газар, БНСингапур Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл, Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын СБЗ-ийн банкны хооронд байгуулсан Эрчим хүчний салбарын I хөтөлбөрийн нэмэлт зээлийн гэрээг соёрхон батлах тухай хуулийн төсөл, Дөргөний УЦС-ыг барьж байгуулах төслийн хүрээнд импортоор нийлүүлэгдэх бараа материал, тоног төхөөрөмжийг гаалийн болон НӨТ-аас чөлөөлөх тухай хуулийн төслүүд, Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцийн нэмэлт, өөрчлөлтөд хамаарах Монреалын Протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөл зэрэг хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, Улсын Их Хуралд өргөн барив.

## 1. ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН БОДЛОГО

Монгол улсын 2005 оны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн тухай Монгол улсын Засгийн газрын (2004 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцүүлж, энэхүү төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэр гаргуулав. Монгол улсын 2005 оны төсвийн хүрээний мэдэгдлийн дунд хугацааны эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, судалгааг гаргаж, 2005 онд хүрэх макро эдийн засгийн түвшинг тодорхойлов. Монгол улсын 2005 оны төсвийн орлого, зарлагын төслийг макро эдийн засгийн түвшинтэй уялдуулан тооцож, төсвийн хүрээний 2005 оны үзүүлэлтүүдийн харьцааг нарийвчлан боловсруулав. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын ба зээлийн 2005 оны төслийг салбар болон улсын дүнгээр нэгтгэн боловсруулж, төсвийн хүрээний мэдэгдлийн холбогдох тооцоо, үндэслэл, тайлбар, танилцуулгыг бэлтгэсэн байна.

Монгол Улс, Олон улсын хөгжлийн нийгэмлэгийн хооронд байгуулах “Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах хоёр дахь шатны төсөл”-ийн хөгжлийн зээлийн гэрээнд Вашингтон хотноо гарын үсэг зурсан байна.

Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлын удирдлага, зохион байгуулалтын бүтцийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, тогтоол гаргахаар шийдвэрлэв.

Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт оруулах тухай, Хүн амын орлогын албан татварын хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тарифын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2004-4-22) хуулиудыг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулав.

Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Сэргээн босголтын зээлийн банкны хооронд байгуулсан Эрчим хүчний салбарын нэгдүгээр хөтөлбөрийн нэмэлт зээлийн гэрээг соёрхон батлах тухай (2004-4-23) хуулийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулав. Энэхүү гэрээний дагуу 4.7 сая еврогийн зээлийн хөрөнгөөр Дарханы дулааны цахилгаан станцын зарим тоног төхөөрөмжийг шинэчлэхийн зэрэгцээ төвийн эрчим хүчний сүлжээний цахилгаан гүйдлийг хянах тоолуурын нэгдсэн тогтолцоо зэргийг сайжруулах болно.

Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийн баримт бичгийг УИХ-ын тогтоолоор батлуулав. Сүүлийн үеийн нийгэм, эдийн засгийн ба төсөв, санхүүгийн салбарын хөгжлийн явцад төрийн албаны үйлчилгээ, түүний үр ашиг болон олон талт үр чадварыг тасралтгүй дээшлүүлэх шаардлага урган гарсан юм. Үүнтэй уялдуулан энэхүү стратегийн баримт бичигт төрийн албаны өнөөгийн байдалд үнэлгээ, дүгнэлт хийж, түүний үр

нөлөөтэй үйл ажиллагаа явуулах, хариуцлага хүлээх чадварыг бэхжүүлэх чиглэлийг тусгасан байна.

Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай (2004-4-15) хуулийг УИХ-аар батлуулав. Европын Сэргээн босголт, хөгжлийн банкны захирлуудын жилийн уулзалтад Санхүү, эдийн засгийн сайд тэргүүдтэй төлөөлөгчид (энэ сарын 17-20-ны өдрүүдэд) оролцлоо. Монгол улс 2000 онд Европын Сэргээн босголт, хөгжлийн банкны хувьцаа эзэмшигч эрх бүхий гишүүн орноор элссэн билээ. Үүнээс хойш 3 жилийн дараа тодорхой үнэлэлт, дүгнэлт хийгдсэний дагуу тус банкны дүрэмд өөрчлөлт оруулснаар Монгол улс зээлжих эрхтэй 62 гишүүн орны тоонд 2004 оноос багтах боллоо. Зохих бичиг баримтыг бүрдүүлсний дараа ирэх оноос манай улсын хувийн хэвшлийн томоохон аж ахуйн нэгжүүд энэхүү төслийн зээл авах эрхийг эдлэх боломжтой болсон байна.

Монгол улсын нэгдсэн төсвийн I улирлын төсвийн гүйцэтгэлийг нэгтгэн боловсруулж мэдээлэв. Энэхүү мэдээгээр төсвийн нийт орлого 137.4 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөө 21.3 хувиар давж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 45.5 тэрбум төгрөгөөр буюу 49.5 хувиар өссөн байна. Улсын нэгдсэн төсвийн зарлага 132.8 тэрбум төгрөг болж төлөвлөгдсөн нийт зарлагын 86.6 хувийг санхүүжүүлсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс зарлага санхүүжилт 19.2 хувиар өссөн байна. Эхний улиралд төсвийн урсгал тэнцэл (өссөн дүнгээр) 19.7 тэрбум төгрөг, нийт тэнцэл 4.6 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын барилга болон сумдад баригдах 4 эмнэлгийн барилга, Орхон-Хөтөлийн цэвэр усны шугам, Нийслэлийн гэр хорооллын Цагдаагийн хэсгийн барилга, Ховд аймгийн Булган, Өвөрхангай аймгийн Гучин-Ус, Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын цахилгаан дамжуулах шугам, дэд өртөө, “Геомэдээллийн сан” хөтөлбөрийн хүрээнд тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, худалдан авах зэрэг 8 тендерийн хороо, үнэлгээний хэсгийг байгуулах шийдвэрийг гаргуулж, тендерийн баримт бичгийг боловсруулав. Улсын төсвийн хөрөнгөөр 2004 онд шинээр гүйцэтгэх геологийн судалгааны 10 төсөл, ерөнхий боловсролын сургуулиудын компьютер хангамжийг сайжруулах төсөл, сумдын эмнэлгийн 11 барилгын болон ЦЕГ-ын 801-р ангийн штабын барилга, Хил хамгаалах ерөнхий газарт хүнд даацын автомашин нийлүүлэх гүйцэтгэгчийг тус тус сонгон шалгаруулав. Захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан 28 гэрээг хянан батлуулав. Нийтдээ 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эрх нээж олгов.

Улсын төсөвтэй харьцдаг төсөвт байгууллагуудын 2004 оны 3 дугаар сарын зарлагын мэдээг нэгтгэн гаргаж мэдээлэв. Улс, орон нутгийн төсөвтэй харилцагч төсөвт байгууллагуудын 3 дугаар сарын өр, авлагын мэдээг батлагдсан маягтын дагуу нэгтгэн гаргав. Улсын хэмжээнд 4 дүгээр сарын 1-ний байдлаар нийт авлага 3.4 тэрбум, өр 4.9 тэрбум төгрөгт хүрсэн мэдээтэй байна.

Санхүү, эдийн засгийн яамны 4 жилийн үйл ажиллагааны тайлан, Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн эхний улирлын дүн сэдвээр хэвлэлийн бага хурлыг 2 удаа зохион байгуулав. Сэтгүүлч Т.Мөнхтунгалагийн “Засгийн газар бохир мөнгө угаагаагүйг шүүх нотлоогүй”, П.Ганхуягийн “Монгол улс өрийн дарамтад орсноо нуух аргагүй боллоо” гэсэн сонины ярилцлагуудад няцаалт бэлтгэж нийтлүүлэв.

## **ҮЙЛДВЭР, ХУДАЛДАА**

Хаягдал төмрийн экспортын гаалийн татварын асуудлаар “Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг боловсруулан, Засгийн газрын хуралдаанд оруулж хэлэлцүүлэв.

Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Арабын Бүгд Найрамдах Египет Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл, Монгол Улс, АНУ-тай байгуулах Худалдаа, хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулсан байна.

“Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн байршил, хилийн заагийг тогтоох тухай асуудлыг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэв.

Ой, модны үйлдвэрлэлийг түшиглэн байгуулсан тосгоны талаар авах арга хэмжээний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд хөдөлмөр эрхлэлт, ажлын байр нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд зориулан Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас зээл олгох тухай асуудлыг холбогдох аймгийн Засаг дарга нарт мэдэгдсэн байна.

2004 оноос шинээр эхлэх геологийн судалгааны 10 ажлын геологийн даалгаврыг боловсруулан баталгаажуулав.

Японы Жайка, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран “Монгол орны геологи, геоэкологийн асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгууллаа.

ДХБ-тай хамтран “Худалдааны хэлэлцээ хийх арга барил” сэдэвт Азийн бүс нутгийн сургалтыг зохион байгуулав.

“Үйлдвэр, худалдааны яамны 2000-2004 онд хийсэн ажлын тайлан” танилцуулгыг бэлтгэж, Үйлдвэр, худалдааны сайд Хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдөд мэдээлсэн байна.

## 2. НИЙГМИЙН БОДЛОГО

2003-2012 оныг Ази, Номхон далайн бүсийн тахир дутуу иргэдийг дэмжих 10 жил болгон зарласантай холбогдуулан энэ ажлыг Монгол Улсад эрхлэн зохион байгуулах Үндэсний хороог байгуулж ажилд оруулав.

Монголын хараагүйчүүдийн нийгэмлэгээс тавьсан шаардлагыг шийдвэрлэх талаар хийж буй ажлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, уг шаардлагын дагуу холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нар тодорхой арга хэмжээ авч байна.

Монгол улсын төрөөс “Хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлж батлуулав.

“Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”-ийн ажлын төлөвлөгөөний дагуу Гэр бүлийн хөгжлийн төвийг байгуулан ажиллуулах бэлтгэл ажлыг хангалаа. Гэр бүлийн хөгжлийн төв байгуулснаар гэр бүлд зөвлөлгөө өгөх, гэр бүлийн асуудлаар сургалт зохион байгуулах, мэдээллийн сүлжээ байгуулах зэрэг үйл ажиллагааг цогцоор зохион байгуулах боломжтой болох юм. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын хэмжээнд Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан төлөвлөгөөтэй ажиллуулж байна.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 2002-2003 оны гурван талт хэлэлцээрийг нийгмийн түншлэгч талуудыг оролцуулан 2004 оны 4 дүгээр сард дүгнэж, дүнг нийтэд мэдээлэв. Хэлэлцээрт тусгагдсан 53 асуудлын 91 хувь нь бүрэн биелсэн байна.

“Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн заалтыг үндэслэн “Ти Си Ай” ХХК, “Цуки” ХХК, “Оюунтүлхүүр” ТББ-ын Япон улсын холбогдох компаниудтай байгуулсан гэрээний дагуу нийт 26 хүнийг Япон улсад, “Монгол ньус” ХХК-ний БНСУ-ын Жижиг дунд үйлдвэрийн холбоотой байгуулсан гэрээний дагуу 28 хүнийг үйлдвэрлэлийн дадлагажигчаар илгээх ажлыг зохион байгуулав.

2004 оны эхний 4 сарын нийгмийн даатгалын тэтгэвэрт 25,8 тэрбум олгож, тэтгэврийг хугацаанд нь бүрэн олгосон байна. Мөн хугацаанд нийгмийн халамжийн тэтгэвэрт 1,6 тэрбум төгрөгийг 47225 хүнд, нийгмийн халамжийн тэтгэмжид 2,4 тэрбум төгрөгийг 65103 хүнд тус тус олгосон байна.

## БОЛОВСРОЛ

“Бүх нийтийн боловсролын долоо хоног”-ийн арга хэмжээний хүрээнд Бүх нийтийн боловсролын форумын хурлыг зохион байгуулав. Уг арга хэмжээнд Бүх нийтийн боловсролын форумын гишүүн гадаад, дотоодын байгууллагууд, аймаг, нийслэлийн Боловсролын газрын албан бус боловсролын арга зүйчид оролцов.

Бүх нийтийн боловсролын үндэсний төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах талаар ЮНЕСКО-гийн Парисын төв, Бээжин дэх суурин төлөөлөгчийн газар, БНСУ-ын Боловсролын хөгжлийн хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлэх төслийг эцэслэн боловсруулж, санхүүжилтийг батлуулав.

БСШУС-ын 2004 оны 100 дугаар тушаалаар сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын стандартын туршилтын үйл ажиллагааны төлөвлөгөө, туршилтанд хамрагдах

сургууль, цэцэрлэгийг батлан туршилтын багийг томиллоо. Энэ ажлын хүрээнд бага, дунд боловсролын шинэ стандартын туршилтын сургууль, цэцэрлэгийн хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх хоёр өдрийн сургалтыг зохион байгуулж, туршилтад хамрагдах Булган, Төв, Дорноговь аймаг, нийслэлийн ЕБС-ийн багш нарын төлөөлөл бүхий 80 хүн оролцов.

“Улсын шалгалтын сэдэв, сорил/тест/ боловсруулах, битүүмжлэх, нууцлах асуудлаар БСШУЯ ба Боловсролын үнэлгээний төвийн хооронд гэрээ байгуулав.

“Хүүхэд аюулгүй орчин “ хоёр сарын аяны нээлтийг зохион байгуулж, энэ хүрээнд ЕБС-ийн сурагчдаас үйлдэж буй гэмт хэргийг бууруулахад чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулж байна.

“Ерөнхий боловсролын тулгамдсан асуудлууд” сэдэвт телевизийн шууд нэвтрүүлэг явуулж, ЕБС-ийг 11 жилийн тогтолцоонд шилжүүлэх, бага, дунд боловсролын шинэчилсэн стандартыг хэргжүүлэхтэй холбогдсон асуудлаар тодорхой мэдээлэл өгч, хөдөлмөрчдийн асуултад хариу өгөв.

Хятадын Гуанжоу хотноо болсон “Хөгжиж байгаа орнуудын шинжлэх ухаан, технологийн бодлого” олон улсын хуралд “Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн бодлого, өнөөгийн байдал цаашдын төлөв хандлага” сэдвээр илтгэл тавив.

Дээд боловсролын 20 гаруй байгууллагын тусгай зөвшөөрлийг хянаж бүртгэлийг шинэчлэсний зэрэгцээ дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчдийн дипломын дугаар 5000 гаруйг олголоо.

“Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийг эцэслэн боловсруулж, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав.

БНХАУ-ын соёлын өдрүүдийг 2004 оны 4 дүгээр сарын 4-13-ны өдрүүдэд зохион байгуулж, энэ үеэр хөгжмийн зэмсэг, фото зургийн үзэсгэлэн гаргаж, урлагийн болон циркийн тоглолт зэрэг арга хэмжээ явууллаа.

“Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын соёл, шинжлэх ухаан, боловсролын салбарын хамтын ажиллагааны тухай хамтарсан комиссын анхдугаар хуралдааны Протокол”-ын төсөл болон “Монгол Улсын Засгийн газар, Арабын Бүгд Найрамдах Египет Улсын Засгийн газар хооронд боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт 2004-2006 онд хамтран ажиллах Хөтөлбөр” байгуулах асуудлыг Засгийн газрын хуралд оруулж, зохих шийдвэрийг гаргуулав.

Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд боловсрол, соёл, урлаг, шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээг иргэд, олон нийтэд сурталчлах зорилгоор “Айл бүрт, хүн бүхэнд хүрсэн төрийн үйлчилгээ” гэсэн 45 минутын видео киног бүтээж, орон нутагт хүргүүлэхэд бэлтгэж байна.

## ЭРҮҮЛ МЭНД

Нийслэлээс хөдөө орон нутагт дуудлагаар очиж үзүүлэх эмнэлгийн төрөлжсөн нарийн мэргэжлийн түргэн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2004 оны 81 дүгээр тушаалаар алсын түргэн тусламжийг зохицуулах журам, алсын дуудлага дуудах өвчний жагсаалтыг тус тус батлан мөрдүүлсэн байна. ДЭМБ-тай хамтран хэрэгжүүлж байгаа “Орчны эрүүл мэнд” төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө, ДЭМБ-ын шийдвэрийг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2004 оны 82 тоот тушаалаар “Гэрийн доторхи агаарын бохирдлын эрүүл мэндийн нөлөөллийн судалгаа” төслийн ажилд зориулан 9,4 сая төгрөгийн үнэ бүхий багаж, тоног төхөөрөмжийг НЭМХ-т шилжүүлэв.

2004 оны зуны Олимпын наадамд бэлтгэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2004 оны 75 дугаар тушаалаар Олимпын наадамд оролцох эрх авсан тамирчид, тэдгээрийн үндсэн дасгалжуулагч нарт Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлгийг олгох, эрх авсан тамирчид, тэдгээрийн бэлтгэл хангагч нарыг эрүүл мэндийн тусгай хяналтад хамрах арга хэмжээ авчээ.

Шинээр бүтээгдсэн эмийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2004 оны 86 дугаар тушаалаар “Монгол улсад шинээр бүтээгдсэн эмийг баталгаажуулах журам”-ыг батлан мөрдүүлсэн байна.

“Эрүүл мэндийн тухай” хуулийн заалт, Эрүүл мэндийн магадлан итгэмжлэл, зөвшөөрлийн зөвлөлийн 2004 оны 3 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн Эрүүл мэндийн

сайдын 2004 оны 79 дүгээр тушаалаар “Эмчлэх, сувилах, эм барих мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл”-ийг 240 их эмч, эм зүйч, 93 эмнэлгийн мэргэжилтэн, шалгаруулалтын болзол хангасан гадаадын 13 их эмч, 7 эмнэлгийн мэргэжилтэнд тус тус олгож, эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны технологи, стандартын хэрэгжилт, тусламж үйлчилгээний чанарын шаардлага хангасан 57 эмнэлэгт магадлан итгэмжлэл олгохоор шийдвэрлэжээ.

Засгийн газрын 2002 оны 129 дүгээр тогтоолын заалтыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2004 оны 91 тоот тушаалаар заавал хийх дархлаажуулалтын үндэсний төвлөлд улаанбурхан, гахай хавдар, улаанууд/УГУ/-ын эсрэг хавсарсан вакциныг нэвтрүүлэх судалгааны ажлын загварчилсан төлөвлөгөө, уг вакциныг тарих заавар, нэвтрүүлэхэд эрүүл мэндийн байгууллагаас гүйцэтгэх үүрэг, вакцины дараа гарч болзошгүй урвал, хүндрэлийг бүртгэх, мэдээлэх заавар, судалгааны хуудсыг тус тус баталсан байна.

Монгол улсын ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн даргаас Шувууны томуу өвчнөөс сэргийлэх талаар өгсөн үүргийн дагуу Эрүүл мэндийн яамнаас хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан Эрүүл мэндийн сайдаар батлуулан хэрэгжүүлж, ажлын дүнг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэв.

АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “SARS ба дахин сэргэж байгаа халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх үндэсний чадамжийг бэхжүүлэх нь” төслийн 2 дахь хэсгийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, зүүн бүсийн аймгуудын сум, өрхийн эмч нарт SARS ба дахин сэргэж байгаа халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх талаар сургалт зохион байгуулав.

2004 оны 4 дүгээр сарын нэгний байдлаар Монголэмимпекс компанийн агуулахад 241 төрлийн 1309,8 сая төгрөгийн, орон нутгийн эм хангамжийн компаниудад 86-179 нэрийн 570,4 сая төгрөгийн эмийн үлдэгдэлтэй, Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн хангамж Улаанбаатар хотод 86,0 хувь, орон нутагт 87,0 хувьтай байна.

### 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО

Усны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны хурлаар хэлэлцүүлэн Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар батлуулав.

“Гамшгаас хамгаалах улсын албадын удирдлагын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиглэл”-ийн дагуу “Байгалийн болон химийн аюулыг үнэлж мэдээлэх улсын алба”-ыг холбогдох мэргэжилтэн, албан тушаалтныг оролцуулан байгууллаа.

Засгийн газрын тогтоолын дагуу Говийн бага дархан цаазат газрын “Б” хэсэгт хууль бусаар алт олборлосон үйл ажиллагаанд дүгнэлт хийж, улсын тусгай хамгаалалттай газар нутагт дахин зөрчил гаргуулахгүй байх талаар урьдчилан сэргийлэх, зөрчил илэрсэн тохиолдолд цаг алдалгүй таслан зогсоох, хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор шуурхай ажлын штаб байгуулан ажиллаж байна.

Эрүүл мэндийн яам, дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Байгаль орчны яам, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн хамтран зохион байгуулсан “Цэвэр усны булаг” төслийн нээлтийн семинар, Азийн хөгжлийн банкнаас зохион байгуулсан “Монгол орны байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг илүү оновчтой болгох, байгаль орчны хөгжлийн хүрээнд тулгарч буй бэрхшээлүүд, менежментийг сайжруулах тухай” ярилцлага зэрэгт оролцож, санал солилцов.

“Нөхөн сэргээгдэх байгалийн нөөц баялгийн концессийн гэрээгээр эзэмшүүлэх нь” сэдэвт семинарыг ХБНГУ-ын Техник хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Байгаль хамгаалал, байгалийн нөөцийн тогтвортой менежмент” төсөлтэй хамтран зохион байгууллаа.

Нийслэлийн ногоон бүсэд Ойн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих ажлаар Улсын мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газартай хамтарч Шарга морьт, Бэлх, Сэлх, Сэлбэ, яргайт, Хандгайт, Улиастай, Санзай аманд ой ашиглалтын байдалд шалгалт хийж, зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллаж байна.

### 4. БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

## ХӨДӨӨ АЖ АХУЙ

“Тариалангийн тухай” хууль, “Усны тухай” хуулийн шинэчилсэн найруулга, “Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулиудыг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулав.

“Хүнс, хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэл-шинэ технологи сан”-гийн журмын төслийг Засгийн газрын хуралдаанд оруулан хэлэлцүүлж тогтоол гаргуулав.

НХХЯ, АХБ-ны Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөр, Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг тодорхойлох нь зөвлөлдөх уулзалтыг зохион байгууллаа.

Хаваржилтын байдал онцгой хүндэрсэн зарим сумдад үзүүлэх тусламж шуурхай арга хэмжээний тухай Засгийн газарт танилцуулж, Төв аймгийн Угтаал, Цээл, Сэлэнгэ аймгийн Орхонтуул, Орхон аймагт хаагдсан зам давааг онгойлгох, малчдад өвс тэжээл хүргэхэд шаардагдах зардлыг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргах асуудлыг шийдвэрлүүллээ.

Тариалалтад дутагдах үрийг Улсын нөөц, Буудайн сангаас гаргах тухай Засгийн газрын тогтоол гаргуулж, 2004 оны хаврын тариалалтад дутагдах үрийн захиалгыг аж ахуйн нэгж бүрээр гаргаж зохион байгуулсан байна.

Булган, Сэлэнгэ, Дархан-уул, Төв аймгуудын хаврын тариалалтын технологийн зөвлөлгөөнд оролцож, Төрөөс газар тариалангийн салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, цаашдын зорилтын талаар мэдээлэл хийв.

КР-1 төслийн хүрээнд ирсэн 19,0 тонн улаан буудай хүлээн авах ёслолын ажиллагааг зохион байгуулж, улаан буудайг борлуулах үнийг тогтоох, хөрөнгө төвлөрүүлэх тухай шийдвэр гаргаж, улаан буудайг аймаг орон нутаг, аж ахуйн нэгжийн захиалгын дагуу олгох ажлыг зохион байгуулж байна.

“Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр, Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжүүлж байгаа “Хөдөө аж ахуйн хөгжлийн хөтөлбөр” төслийн 2003 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг хөтөлбөрийн үндэсний зөвлөл, төслийн удирдах зөвлөлийн хуралдаанд тус тус хэлэлцүүлэв.

## ДЭД БҮТЭЦ

Хийн түлш болон хийн тоног төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн татвараас, хийн салбарт үйл ажиллагаагаа эрхлэгч аж ахуйн нэгжийг орлогын албан татвараас чөлөөлөх тухай хуулиудын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн барив.

УИХ-ын чуулганд “Эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр” сэдвээр Дэд бүтцийн сайд мэдээлэл хийв.

БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжих Монгол Улсын Замын-Үүд-Улсын хил-БНХАУ-ын Эрээний чиглэлд баригдах авто замыг сайжруулах төслийн зураг төслийг гүйцэтгэгч компанитай ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулав.

Авто тээврийн салбар, Замын салбар, Түлш, эрчим хүчний салбар болон Төмөр замаар үйлчлүүлэгч байгууллага, төмөр замын өртөөний удирдах ажилтны зөвлөлгөөнийг тус тус зохион байгуулж, салбарын хэмжээнд баримталж байгаа бодлого, цаашид авах арга хэмжээний тухай хэлэлцэн, тулгамдаж байгаа асуудлыг хэрэгжүүлэх талаар зөвлөмж гаргасан байна.

Ази, Номхон далайн орнуудын цахилгаан холбооны байгууллага, Дэлхийн худалдааны байгууллага, Дэд бүтцийн яам хамтран “Зүүн Азийн орнуудын цахилгаан холбоо ба худалдаа” сэдэвт олон улсын уулзалт семинарыг Улаанбаатар хотноо зохион байгуулав.

Дэд бүтцийн салбарын 2004-2005 оны өвөлжилтийн бэлтгэл хангах асуудлаар Дэд бүтцийн сайдын тушаал гаргаж харъяа газруудад хүргүүлэн биелэлтийг зохион байгуулах арга хэмжээ авч байна.

Дэд бүтцийн яам, Мэдээллийн технологийн үндэсний парк, МИДАС ТББ хамтран “Монгол программ хангамж-2004” үзэсгэлэн-худалдааг Улаанбаатар хотноо зохион байгуулж, мэдээлэл холбоо, программ хангамжийн 20 гаруй байгууллага, компанийг оролцуулав.

“Барилгын материал, шинэ технологи-2004” олон улсын үзэсгэлэнг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулав.

## 5. БАТЛАН ХАМГААЛАХ, ГАДААД БОДЛОГО

### БАТЛАН ХАМГААЛАХ

“Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай”, “Цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай” хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж бэлэн болгов.

Монгол Улс, АНУ-ын хамтарсан “Батлан хамгаалах нөөцийн менежментийн тогтолцоог боловсронгуй болгох, үнэлэх нь” төслийг боловсруулах хамтран хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна.

“Монгол Улсын нутаг дэвсгэрт цэргийн зориулалтаар ашиглаж байсан газар нутгийн байдал түүнийг сэргээх нь” хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хүрээнд экологийн байдлыг сайжруулах талаар аймгуудаас боловсруулж ирсэн хөтөлбөр, төслийг нэгтгэн уг асуудлаар зохион байгуулах олон улсын онол практикийн бага хурлын бэлтгэл ажил хийгдэж байна.

Батлан хамгаалах яамнаас Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар, сумдын Тамгын газрын ажилтнуудтай “Сумдын дайчилгааны төлөвлөгөө боловсруулах аргачлал” сэдэвт сургалт-семинарыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгч ажиллав.

Хятадын ардын чөлөөлөх армийн Жанжин штабын орлогч дарга, хурандаа генерал Сюн Гуанкай тэргүүтэй төлөөлөгчид, ХБНГУ-ын Энхийг сахиулах хүчний сургалтын төвийн захирал генерал Бергер тэргүүтэй төлөөлөгчид, АНУ-ын Номхон далай дахь Агаарын цэргийн хүчний төлөөлөгчид тус тус манай оронд айлчлан, Батлан хамгаалах яамны төлөөлөгчид БНХАУ-д ажлын айлчлал хийсэн нь Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болов.

Засгийн газрын хуралдаанд Зэвсэгт хүчний 073 дугаар анги, засвар-механизмын заводын талаар авах арга хэмжээний тухай, Зэвсэгт хүчний дайчилгааны нөөцөөс зарим төрлийн хувцас хэрэгсэл гаргах тухай зэрэг асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, хэрэгжилтийг ханган ажиллав.

Болзошгүй террорист үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх түүнтэй тэмцэх чиглэлээр гарсан Батлан хамгаалахын сайдын 2002 оны 505 дугаар тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангав.

Зэвсэгт хүчний анги, салбаруудын байлдааны бэлэн байдлыг зохих түвшинд байлгах, зарим ангиудын байлдааны болон дайчилгааны бэлэн байдлыг шалгаж үнэлэх, Сургалтын хөдөлгөөнт багийн хоёрдугаар ээлжийн бэлтгэлийг хангаж Афганистанд илгээх, анги, салбаруудын хээрийн гаралт, полигоны дадлага, байлдааны буудлагатай, буудлагагүй тактикийн хээрийн сургуулийг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах, Зэвсэгт хүчний зарим ангиудад командлалын шалгалт явуулах, анги, салбаруудын цэргийн албаны зохион байгуулалт, сахилга, дэг журмыг дээшлүүлэх зэрэг ажлуудад гол анхаарлаа чиглүүлэн ажиллав.

Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын жижүүрүүдэд зарлан мэдээллийн дадлагын дохио нэг удаа өгч, анги, салбаруудаа хэрхэн удирдаж байгааг шалган цаашдын ажиллах чиглэл, арга хэмжээний талаар үүрэгжүүллээ.

Цэргийн сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу анги, салбаруудын хээрийн гаралт, полигоны дадлага, байлдааны буудлагатай, буудлагагүй тактикийн хээрийн сургуулийг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллав.

Зэвсэгт хүчний холбоочдын тусгай тактикийн хээрийн сургуульд бүх ангиудын холбоочид, тусгай холбоочид оролцож, радиостанцаа дэлгэх, тохируулах, холбоо тогтоох, бодит болон сургуулийн мэдээлэл солилцох, дадлага сургууль хийж, ур чадвараа дээшлүүлэв.

Зэвсэгт хүчний ангиудад батлагдсан төлөвлөгөө хуваарийн дагуу ар талын бүх төрлийн хангалтыг зохион байгуулж байна.

## ГАДААД БОДЛОГО

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Арабын Бүгд найрамдах Египет Улс, Бүгд найрамдах Турк Улсад хийх албан ёсны айлчлалын бэлтгэл ажлыг хангаж, ажиллав. Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр байгуулах Монгол Улс, БНТУ-ын хамтын ажиллагааны тухай хамтарсан мэдэгдлийн төсөл, ярианы сэдэв, лавлах, танилцуулга зэрэг баримт бичгийг боловсруулав.

Токио хотноо 3 дугаар сарын 26-27-нд болсон Ази дахь ардчилсан засаглалын асуудлаарх олон улсын хуралд Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун тэргүүтэй төлөөлөгчид оролцох бэлтгэлийг хангав.

Улаанбаатар хотноо болсон Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын комиссын бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны дэд комиссын ээлжит хуралдааныг зохион байгуулахад оролцож, хуралдааны дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулав.

Британийн Гадаад болон хамтын нөхөрлөлийн хэргийн яамны Парламентын харилцааны газрын дарга Матью Хамлин 3 дугаар сарын 29-өөс 4 дүгээр сарын 2-ны өдрүүдэд УИХ-ын Тамгын газрын шугамаар Монголд ажлын айлчлал хийж, холбогдох албаны хүмүүстэй уулзан манай УИХ-ын хууль тогтоох үйл ажиллагаа, УИХ-аас Ерөнхийлөгч, Ерөнхий сайд болон төрийн бусад байгууллагуудтай хэрхэн харилцдаг талаар санал солилцов.

УИХ-ын даргын Италид хийсэн айлчлалын үеэр ярилцаж тохирсон хоёр орны Парламент хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилтын хүрээнд Италийн Парламентын зөвлөх хатагтай Антонелла Деледа 3 дугаар сарын 29-нөөс 4 дүгээр сарын 2 хүртэл УИХ-ын Тамгын газарт ажиллав.

АНУ-ын элчин сайд П.Слуц 4 дүгээр сарын 13-нд Ерөнхийлөгч Н.Багабанди, Ерөнхий сайд Н.Энхбаяр, УИХ-ын дэд дарга Ж.Бямбадорж нартай тус тус уулзав. Элчин сайд Вашингтонд очиж, ажилласан тухйгаа мэдээлж, хоёр талын харилцааны зарим асуудлаар ярилцав.

Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун АНУ-ын элчин сайд П.Слуцийг хүлээн авч уулзах үеэр айлын тал энэ онд тусламжийн 50 мянган тонн улаанбуудай нийлүүлэхээр төлөвлөж байгаагаа мэдэгдэв. Энэхүү тусламжийг Дэлхийн зөн, Мерси Кор байгууллагуудын шугамаар нийлүүлэх гэж байгаа аж.

Мянганы сорилтын дансанд Монгол Улсыг хамруулах үүрэг бүхий манай талын ажлын хэсэг Мянганы сорилтын дансны Монгол Улсын бодлогын баримт бичгийг боловсруулж эцэслэв. Энэхүү баримт бичгийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж үндсэнд нь дэмжлэг авав. Уг баримт бичгийг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн Монгол дахь төлөөлөгчийн газарт танилцуулав.

БНСУ-ын Хөдөлмөрийн яам гадаадын ажилчдын тухай хууль ирэх 8 дугаар сараас хэрэгжихтэй холбогдуулан шинэ хуулийн дагуу гэрээгээр ажиллуулах тогтолцоогоор 25 мянга, жижиг, дунд үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарт үйлдвэрлэлийн дадлага хийлгэх тогтолцоогоор 38 мянган хүнийг хүлээн авна. Гэрээгээр ажиллуулахтай холбогдсон Санамж бичгийг хоёр орны холбогдох яам хооронд 4 дүгээр сард байгуулахаар ажиллаж байна.

Хүнсний хангамжийг сайжруулах КР-1 төслийн хүрээнд 100 сая иенийн тусламж авах тухай Ноот бичигт Гадаад хэргийн сайд, Японы элчин сайд нар 4 дүгээр сарын 2-ны өдөр Улаанбаатарт гарын үсэг зурав.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд гадаад харилцааны сэдвээр хэвлэлийн мэдээ 28-ыг бэлтгэн тарааж, хэвлэлийн бага хурал гурвыг зохион байгуулав.

## 6. ЗАСАГЛАЛ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОДЛОГО

Засгийн газар Яамны эрх зүйн байдлын тухай, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлж батлуулав.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Засгийн газрын хуралдааны 2004 оны нэгдүгээр улирлын дүнгийн тухай Засгийн газрын хуралдаанд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан асуудлыг энэ оны 5 дугаар сарын 15-ны дотор Засгийн газрын хуралдаанд оруулах арга хэмжээ авч байна.

Түүнчлэн Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцыг 2004 оны нэгдүгээр улирлын байдлаар гаргаж, Засгийн газрын хуралдаанд танилцуулав. Хяналтад авсан 2868 тогтоол, шийдвэрийн 3907 заалтын 98,3 хувь нь биелсэн дүнтэй байна. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрээс биелэлт нь удааширч байгаа заалтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна.

Иргэдээс 2004 оны нэгдүгээр улиралд Засгийн газарт хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал, түүнд тусгагдсан асуудлын Засгийн газрын хуралдаанд танилцуулав.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн тухай асуудлыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.Энхтүвшин Засгийн газрын хуралдаанд танилцуулав. Энэ үндсэн дээр Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, шаардлагатай журам, зааврыг шинээр гаргах хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээг төлөвлөн үе шаттай хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны 2004 оны нэгдүгээр улирлын товч мэдээллийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2004 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан бодлогын зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг хугацаанд нь бүрэн биелүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлэн ажиллаж байна.

Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дүн, Хурал, Тэргүүлэгчдээс 2003 онд зохиосон ажлын дүнг нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулав. Үүнтэй холбогдуулан аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн үйл ажиллагаанд гарсан шинэлэг арга барил, анхаарах асуудлын талаар Хурлын Тэргүүлэгчдийн дарга нарт мэдээлэв.

Хууль зүй, дотоод хэргийн яам Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хууль тогтоомжийн төслүүдэд санал дүгнэлт бэлтгэсэн байна. Түүнчлэн Хууль бусаар алт олборлож байгаа талаар авах зарим арга хэмжээний тухай, Дээд боловсрол олгодог төрийн өмчийн сургалтын байгууллагын ажил, үйлчилгээг бүтээгдэхүүн нийлүүлэх хэлбэрт шилжүүлэн гэрээгээр гүйцэтгүүлэх журам батлах тухай зэрэг Засгийн газрын 21 тогтоолын төсөл болон Засгийн газрын хуралдааны таван тэмдэглэлийн төсөлд тус тус санал бэлтгэжээ.

“Монгол Улсад хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх “HURIST MON” төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтнуудын сургалт-семинарыг 2004 оны 4 дүгээр сард зохион байгууллаа.

Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн 9 актыг хянан улсын бүртгэлд авч, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл 22, Төрийн бус байгууллага 21, Үйлдвэрчний эвлэлийн байгууллага 29-ийг тус тус бүртгэж, гэрчилгээ олгосон байна.

Төрийн захиргааны холбогдох байгууллагуудын зөвшөөрлийг үндэслэн Монгол улсад албан хэргээр удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийг гадаадын 1319 иргэнд олгож, 365 хүний оршин суух зөвшөөрлийг сунгаж, нутаг буцсан 98 хүнийг бүртгэлээс хассан байна.

Монгол улсад оршин суух, дамжин өнгөрөх болон виз, бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн 15 орны иргэн 85 хүнд Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан арга хэмжээ авч 9,9 сая төгрөг, түүнчлэн 2 уригч, 4 аж ахуйн нэгжийг 3 сая төгрөгөөр тус тус торгон уг мөнгийг улсын орлогод оруулав.

## ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

